



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/112

Улаанбаатар хот

Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих
ажлын хэсэг байгуулах тухай

Нийслэлийн Эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.10, Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.3, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 9/10 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 дугаар албан даалгавар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Гудамж, зам талбайн тохижилтын ажилд хяналт тавьж, тохижилтын ажлын дүнд бий болсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, гудамж зам талбайд аюулгүй орчинг бий болгох, Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний байгууллагуудын орчны 50 метр талбайн зураглалыг хийж, байгууллагуудад хариуцуулан мэдээллийн сан үүсгэж, Худалдаа үйлчилгээ эрхлэх гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулж, тохижилт, ногоон байгууламжийг бий болгох, арчлах, байгууллагын орчны аюулгүй байдлыг хангах зэрэг Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 тоот албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож, дүүрэг хариуцан ажиллах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулсугай.

2. Ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Тохижилтын ажлын дүнд бий болсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, гудамж, зам талбайд аюулгүй орчинг бий болгох, байгууллага аж ахуйн нэгжүүдээр орчны тохижилт ногоон байгууламж цэвэрлэгээний ажлыг гүйцэтгүүлэх ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулж, ажлын явц, хэрэгжилтийг удирдамжид


заасан хугацаанд Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргад танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /Ц.Рэгзэдмаа, Т.Хэрлэн, Г.Ууганбаяр, Э.Энхцэцэг, Б.Эрдэнэчимэг/-т даалгасугай.

4. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 тоот албан даалгаврын 2, 3, 8, 9, 10 дугаар заалтын хэрэгжилтэд Инженерийн байгууламжийн хэлтэс /Т.Хэрлэн/, 4, 5, 6, 7 дугаар заалтын хэрэгжилтэд Тохижилт хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр,/ 11 дүгээр заалтын хэрэгжилтэд Аудит, дотоод хяналтын хэлтэс /Ц.Рэгзэдмаа/ тусгайлан хяналт тавьж, мэргэжлийн байгууллагуудыг чиг үүргээр хангаж, хэрэгжилт, үр дүнг улирал тутам тооцож, дүнг нэгтгэн, тайлагнаж ажиллахыг тус тус үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны 04 сарын 28-ний өдрийн.....
 А.М. дугаар тушаалын дүнд хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТЭД
 ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хариуцах дүүрэг	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Овог нэр	Албан тушаал
Баянзүрх	Ажлын хэсгийн ахлагч	Ц.Рэгзэдмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн дарга
	Гишүүд	Т.Батцогт	Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч
		Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
		Д.Мөнгөндүүлга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
		Т.Оюунтөгс	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
		Б.Отгонбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
		С.Эрдэнэболд	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
		Б.Сүлд-Эрдэнэ	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
		О.Уянга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн
		Б.Мөнхбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
		Э.Дэлгэрмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
Б.Ариунбат	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Баянзүрх дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч		

		Н.Бямбадорж	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Баянзүрх дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч
		Л.Батбаяр	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техник хяналтын улсын ахлах байцаагч
		Б.Чулуунчимэг	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч
		Б.Бадамсүрэн	Баянзүрх Залуучуудын давалгаа НҮТББ-ын хяналтын мэргэжилтэн
		Д.Доржцэнд	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны өндөр настан
	Нарийн бичгийн дарга	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Хан-Уул, Багануур	Ажлын хэсгийн ахлагч	Э.Энхцэцэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
	Гишүүд	Г.Батсайхан	Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч
		Т.Отгонболд	Багануур дүүргийн Засаг даргын орлогч
		Д.Эрдэнэцэцэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн
		Ц.Ганбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
		Э.Батжаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
		Б.Эрдэнэбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
		Г.Аюуш	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
		Д.Лувсанчимэд	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
		З.Мөнгөнзул	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

		Д.Нааяа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
		Г.Анхзаяа	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Багануур дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч
		Л.Лхагвасүрэн	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Хан-Уул дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч
		Х.Наранбаатар	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч
		Л.Эрдэнэбат	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч
		н.Батзаяа	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч
		Э.Хонгорзул	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Чанарын менежер
		С.Солонго	Баянзүрх Залуучуудын давалгаа НҮТББ-ын хяналтын мэргэжилтэн
		Д.Сувдхүү	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны өндөр настан
	Нарийн бичгийн дарга	О.Оджаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Сонгинохайрхан Багахангай	Ажлын хэсгийн ахлагч	Г.Ууганбаяр
Гишүүд		О.Ганбаатар	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын орлогч
		Б.Болормаа	Багахангай дүүргийн Засаг даргын орлогч
		Г.Мөнхчулуун	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны архивын эрхлэгч
		Д.Шийтэр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
		Б.Эрхбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
Н.Мөнхгаамаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн		

		М.Балдандорж	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
		Б.Мөнхзул	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
		П.Чойжилжав	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
		Ч.Байгалмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн
		Г.Анхзаяа	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Багахангай дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч
		Б.Батбаяр	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Сонгинохайрхан дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч
		А.Цэцэгмаа	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч
		Х.Наранбаатар	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч
		А.Урангуа	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч
		Л.Эрдэнэбат	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч
		Д.Ганбадрах	Баянзүрх Залуучуудын давалгаа НҮТББ-ын хяналтын мэргэжилтэн
		Б.Эрдэнэбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны өндөр настан
	Нарийн бичгийн дарга	Г.Билгүүн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Чингэлтэй, Сүхбаатар	Ажлын хэсгийн ахлагч	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
	Гишүүд	Ц.Шижир	Сүхбаатар дүүргийн Засаг даргын орлогч
		Ж.Лхагвасүрэн	Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч
		С.Аригуун	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

		Б.Хонгорзул	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
		Г.Индаръяа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
		Э.Хишигбуян	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
		Л.Алтангэрэл	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
		Б.Халиун	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тооцооны нягтлан бодогч
		Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
		Я.Бадмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн
		Г.Анхзаяа	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Чингэлтэй дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч
		Б.Ванхүү	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Сүхбаатар дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч
		Б.Эрхэмбаяр	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч
		Д.Дэлгэрмаа	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч
		Б.Найрамдал	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч
		Ю.Аюуш	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч
		Э.Балданхүү	Баянзүрх Залуучуудын давалгаа НҮТББ-ын хяналтын мэргэжилтэн
		Н.Батсүмбэрэл	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны өндөр настан
	Нарийн бичгийн дарга	Л.Булган	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Баянгол, Налайх	Ажлын хэсгийн ахлагч	Б.Эрдэнэчимэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Гишүүд	Э.Батбилэг	Баянгол дүүргийн Засаг даргын орлогч
		С.Тунгалаг	Налайх дүүргийн Засаг даргын орлогч
		Б.Цэрмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ахлах нягтлан бодогч
		Э.Уянга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
		Я.Гантуяа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
		Т.Туул	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
		О.Батмөнх	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
		Б.Энхжаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
		Т.Энх-Амгалан	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
		Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
		Г.Анхзаяа	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Налайх дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч
		Б.Алтанзул	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Баянгол дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч
		Г.Өлзийбаяр	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Баянгол дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч
		М.Энхжаргал	Нийслэлийн Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч
П.Чойсүрэн	Нийслэлийн Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч		
З.Очирпүрэв	Нийслэлийн Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч		

		н.Оюунтүлхүүр	Нийслэлийн Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч /
		Б.Сайнбилэг	Баянзүрх Залуучуудын давалгаа НҮТББ-ын хяналтын мэргэжилтэн
		Н.Далхжав	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны өндөр настан
	Нарийн бичгийн дарга	Ш.Чанцалнурмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 03 сарын 31-ний өдрийн.....
1119 дугаар тушаалын дүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг. Ажлын зорилго.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 тоот албан даалгавар, Нийслэлийн удирдлагаас тохижилт, орчны аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр гаргасан аливаа шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулж, тохижилт, ногоон байгууламжийн ажилд хяналт тавьж, ажлын дүнд бий болсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, гудамж, зам талбайд аюулгүй орчинг бий болгох, Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээний байгууллагуудын орчны 50 метр талбайн зураглалыг хийлгэж, байгууллагуудад хариуцуулан, мэдээллийн сан үүсгэж, “Худалдаа үйлчилгээ эрхлэх гэрээ”-гээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, тохижилт, ногоон байгууламжийг бий болгох арчлах, хотын өнгө үзэмжийг дээшлүүлэхэд гарсан зөрчил дутагдлыг шуурхай арилгаж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллах, амрах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Эрх зүйн үндэслэл:

Үйл ажиллагаанд дараах эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болгон мөрдөнө.

- 2.1. Хот байгуулалтын тухай хууль;
- 2.2. Газрын тухай хууль;
- 2.3. Авто замын тухай хууль;
- 2.4. Хог хаягдлын тухай хууль;
- 2.5. Зар сурталчилгааны тухай хууль;
- 2.6. НИТХ-ын 61, 63-р тогтоолоор батлагдсан “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дагаж мөрдөх журам”;
- 2.7. НИТХ-ын 2017 оны 09/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулахад дагаж мөрдөх журам”;
- 2.8. НИТХ-ын 2014 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам”;
- 2.8. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл;
- 2.9. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 тоот албан даалгавар;

Хоёр. Хамрах хүрээ.

Дүүргийн нутаг дэвсгэр дэх гудамж зам, талбай, явган зам, орон сууц, гэр хорооллын дундах нийтийн эзэмшлийн газрыг хамруулна.

Гурав. Хугацаа.

3.1 Ажлын хэсэг Нийслэлийн 9 дүүрэгт 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал ажиллана.

Дөрөв. Ажлын чиглэл.

Ажлын хэсэг 3 үндсэн чиглэлээр ажиллана.

4.1. НИТХ-ын 61, 63-р тогтоолоор батлагдсан “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дагаж мөрдөх журам”, НЗД-ын 2019 оны “Хот нийтийн аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 03 тоот албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

- 4.1.1 Байгууллага, аж ахуйн нэгж бүр орчны тохижилт, ногоон байгууламжийг хийх, цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах, өнгө үзэмж, аюулгүй байдлыг хангуулах талаар хариуцан ажиллах талбайн зураглалыг хийж, баталгаажуулан, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулан ажиллаж, гарсан зөрчил дутагдлыг шуурхай арилгах;
- 4.1.2 Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллага аж ахуйн нэгж иргэдэд мөрдөгдөж буй хууль журам, тавигдах шаардлагын талаар мэдээлэл, үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулах;
- 4.1.3 Аж ахуйн нэгж, байгууллагын орчны талбайн тохижилт, ногоон байгууламж, цэвэрлэгээний ажилд хяналт тавьж ажиллах;
- 4.1.4 “Худалдаа үйлчилгээ эрхлэх гэрээ”-гээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулж, тохижилт, ногоон байгууламжийг бий болгох арчлах, хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх;
- 4.1.5 Хууль тогтоомж, журам, тавигдах шаардлага, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байгууллага аж ахуйн нэгжид дүүрэг, хороо, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, инженерийн дэд бүтцийн байгууллагуудтай хамтран арга хэмжээ авах;
- 4.1.6 Хариуцсан дүүргийн нутаг дэвсгэрт хийгдэж буй тохижилт, ногоон байгууламжийн хяналт тавих, гүйцэтгэгч, захиалагч байгууллагад заавар зөвлөмж өгөх, шаардлагатай мэдээллээр хангах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих;
- 4.1.7 Тохижилт, ногоон байгууламж, цэвэрлэгээний чиглэлээр дүүргийн асуудал хариуцсан хэлтэстэй хамтарч ажиллах, дүүргээс тохижилтын чиглэлээр хийгдэж байгаа ажлуудад хяналт тавьж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд мэдээлэх;
- 4.1.8 Орчны тохижилт, ногоон байгууламж, цэвэрлэгээний ажлын талаар олон нийт болон ажил хариуцсан байгууллагуудад мэдээлэл өгөх, сурталчлах;

4.2 Дүүргийн хэмжээнд бүтээн байгуулалт, тохижилт, ногоон байгууламжийн ажлын дүнд бий болсон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эзэмшил, ашиглалтын байдалд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, өнгө үзэмж, аюулгүй байдлыг хангуулж, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийлгэнэ. Хариуцагч байгууллага, холбогдох албан тушаалтанд үүссэн нөхцөл байдлын талаар мэдэгдэж, зөрчил дутагдлыг шуурхай арилгуулна.

Үүнд:

- амралт, спорт, тоглоомын талбай;
- гэрэлтүүлгийн болон гэрлэн дохионы шон, толгой, агаарын кабель;
- хайс, хашлага /ногоон байгууламжийн, барилгын, байгууллага аж ахуйн нэгжийн, авто замын тусгаарлах/;
- сандал;
- хогийн сав;
- явган зам;

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам;
- Авто замын хашлага /бродюр/;
- дугуйн зам;
- авто зогсоол;
- автобусны буудал;
- саравч, сүүдрэвч;
- босоо хэвтээ тэмдэг тэмдэглэгээ;
- хөшөө баримал;
- архитектурын жижиг байгууламж;
- үерийн хамгаалалтын барилга байгууламж, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээ;
- инженерийн шугам сүлжээний бүх төрлийн үзлэгийн худаг, таг;
- гадна зар сурталчилгааны байгууламж, хаяг мэдээллийн байгууламж;
- Усан оргилуур, түүний дагалдах хэрэгсэл;
- Ногоон байгууламж түүний иж бүрдэл /мод, бут, сөөг, зүлэгт талбай, цэцгийн мандал, модны тулгуур, гэрэлтүүлэг/;
- Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 тоот албан даалгаварт тусгагдсан нийтийн эзэмшлийн эд хөрөнгө тохижилтын элемент;

Тав. Зохион байгуулалт

5.1 Нийслэлийн хэмжээнд гудамж зам талбайн тохижилт, ногоон байгууламжийн ажилд хяналт тавьж, тохижилт, ногоон байгууламжийн ажлын дүнд бий болсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, гудамж, зам талбайд аюулгүй орчинг бий болгох, Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний байгууллагуудын орчны 50 метр талбайн зураглалыг хийлгэж, байгууллагуудад хариуцуулан мэдээллийн сан үүсгэж, тохижилт, ногоон байгууламжийг бий болгох арчлах, байгууллагын орчны аюулгүй байдлыг хангуулах ажлыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалаар байгуулсан Ажлын хэсэг удирдан зохион байгуулах бөгөөд дүүрэг бүрт дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан дэд ажлын хэсгүүд ажиллана.

5.2 Ажлын хэсэг, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан дэд ажлын хэсэг, Дүүргийн ЗДТГ, Хорооны Засаг дарга, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, инженерийн дэд бүтцийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл солилцон, орчны тохижилт, ногоон байгууламжийг хийх, өнгө үзэмжийг дээшлүүлэх, аюулгүй орчинг бий болгоход шаардлагатай арга хэмжээг газар дээр нь авч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж ажиллана.

5.3 Ажлын хэсэг дүүргийн нутаг дэвсгэр дэх гудамж талбай, талбар бүрийг хариуцуулан, эзэнжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналтын тогтолцоог бүрдүүлж, дүүргийн нутаг дэвсгэрт орчны аюулгүй байдлыг хангах, байгууллага аж ахуйн нэгжүүд орчноо тохижуулах, цэвэрлэх ажлын менежментийг сайжруулж ажиллана.

5.4 Ажлын хэсгээс явцын үзлэг шалгалтын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлын хүрээнд дүүргийн ЗДТГ, нийслэлийн холбогдох байгууллага, инженерийн дэд бүтцийн байгууллага, гэрээт байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудад зөрчлийн тэмдэглэлийн хуудсаар үүрэг даалгавар өгч, хэрэгжилт үр дүнг тооцож ажиллана.

5.5 Дүүрэг дэх дэд ажлын хэсэг дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулж, аж ахуйн нэгж байгууллага,

иргэдэд орчны тохижилт, ногоон байгууламж, цэвэрлэгээ, аюулгүй байдлыг хангаж ажиллах талбайн зураглалыг хийж, хүлээлгэн өгч, хариуцсан талбай дахь тохижилт ногоон байгууламж, цэвэрлэгээний ажлыг хийлгүүлж орчны аюулгүй байдлыг хангуулж ажиллана.

5.6 Дүүрэг дэх дэд ажлын хэсэг нь Нийслэлийн дүүрэг хариуцсан ажлын хэсгээс өгсөн чиглэлийг хэрэгжүүлж, биелэлт үр дүнг тайлагнаж ажиллана.

5.7 Нийслэл, дүүрэг дэх ажлын хэсэг нь хийгдэж буй ажлын мэдээллийг хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээг ашиглан сурталчилж ажиллана.

5.8 Ажлын хэсэг өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаагүй байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер, удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, арга хэмжээ авч ажиллана.

5.9 Нийслэл, дүүргийн ажлын хэсэг нь “Орчны аюулгүй байдлыг хангах” Нийслэлийн Засаг даргын 04 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх, “Манай хороо-Миний гудамж аян”-ыг зохион байгуулах, “Явган замын тохижилтын ажилд хяналт тавих” үүрэг бүхий ажлын хэсгүүдтэй хамтран ажиллаж, ажлын уялдаа холбоог хангаж ажиллана.

Зургаа. Ажлын үр дүн, тайлагналт.

6.1. Ажлын хэсэг хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг долоо хоног бүр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хуралд, ажлын тайланг улирал бүр Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн шуурхайд танилцуулна.

6.2 Дүүрэг дэх дэд ажлын хэсэг хийж хэрэгжүүлж буй ажлын мэдээ, тайланг сар бүр Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн шуурхайд танилцуулна.